



**СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН
БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**
(Дархан-Уул аймаг, Дархан сум)



Улаанбаатар хот
2022 он



АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА.....	1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2 ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2.1 Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг.....	1-1
1.2.2 Үйлдвэрийн байгууламж	1-1
1.2.3 Үйлдвэрийн хүчин чадал	1-2
1.2.4 Бүтээгдэхүүний найрлага/орцын мэдээлэл	1-3
1.2.5 Үйлдвэрийн үндсэн түүхий эд.....	1-3
1.2.6 Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал	1-4
1.2.7 Үйлдвэрийн тоног төхөөрөмж	1-4
1.3 ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ	1-5
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-6
2.1 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	2-6
2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-1
2.2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-1
2.2.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-4
2.2.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-5
2.2.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-5
2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-6
2.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-7
2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-8
2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	2-11
2.7 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-20
ДҮГНЭЛТ А	
ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	В

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Бетон зуурмагт хэрэглэгдэх материалууд.....	1-3
Хүснэгт 1-2. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт	1-4
Хүснэгт 2-1. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	2-6
Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	2-1
Хүснэгт 2-3. Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	2-4
Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-5
Хүснэгт 2-5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	2-6
Хүснэгт 2-6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	2-7



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 2-7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-9
Хүснэгт 2-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт.....	2-11
Хүснэгт 2-9. Агаарын хэмжилтийн дүн.....	2-15
Хүснэгт 2-10. Дээж авсан байршил.....	2-16
Хүснэгт 2-11. Бетонон зуурмагийн үйлдвэрийн талбай орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалт	2-19
Хүснэгт 2-12. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт	2-20

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил.....	1-1
Зураг 1-2. Ажилчдын байр.....	1-2
Зураг 1-3. Химийн бодисын агуулах.....	1-2
Зураг 1-4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн бүтэц.....	1-3
Зураг 2-1. Үйлдвэрийн хашаан доторх шороон замыг дагтаршуулсан байдал	2-2
Зураг 2-2. Үйлдвэрийн зам талбайг усалж буй байдал.....	2-2
Зураг 2-3. North Benz маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас.....	2-3
Зураг 2-4. Zoomlion маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас.....	2-3
Зураг 2-5. Hyundai маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас.....	2-3
Зураг 2-6. Hyundai маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас.....	2-3
Зураг 2-7. Үйлдвэр ажилчдын байр хоорондын хатуу хучилттай болгосон зам	2-4
Зураг 2-8. Гал унтраах болон саармагжуулах хэрэгсэл	2-5
Зураг 2-9. Үйлдвэрийн хашаанд тарьсан Агч мод	2-6
Зураг 2-10. Ажилчдын байрын үрд тарьсан гацуур, улиас	2-7
Зураг 2-11. Үйлдвэрт суурилуулсан газардуулга	2-8
Зураг 2-12. Ажилчид сургалтад хамрагдаж буй байдал	2-8
Зураг 2-13. Хог хаягдлыг ангилан цуглуулах сав, хогийн цэг.....	2-10
Зураг 2-14. Бетон нэмэлт бодисын сав баглаа боодол	2-10
Зураг 2-15. Хогийн цэг түүний ойр орчимд цэвэрлэгээ хийж буй байдал	2-10
Зураг 2-16. Ил задгай хог хаягдал хаях, бие засахыг хориглосон санамж	2-11
Зураг 2-17. Үйлдвэрийн засварын талбай	2-11
Зураг 2-18. Агаарын дээжлэлт, 09-р сар	2-13
Зураг 2-19. Агаарын хэмжилт, 10-р сар.....	2-15
Зураг 2-20. Хөрсний дээжлэлт, үйлдвэрийн хашаан дотор	2-17
Зураг 2-21. Хөрсний дээжлэлт, машины зогсоол	2-17
Зураг 2-22. Хөрсний дээжлэлт, хяналтын цэг.....	2-17
Зураг 2-23. Хөрсөнд агуулагдах хүнд металлын шинжилгээний дүн.....	2-19
Зураг 2-24. Ургамлын мониторинг хийх явц	2-19
Зураг 2-25. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хуудас	2-21
Зураг 2-26. Ажилчид сургалтад хамрагдсан нь.....	2-22

Графикийн жагсаалт

График 2-1. Үйлдвэрийн талбайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж	2-13
График 2-2. Үйлдвэрийн талбайд хийгдсэн азотын давхар ислийн агууламж	2-14
График 2-3. Үйлдвэрийн талбайд хийгдсэн нийт тоосны агууламж	2-14
График 2-4. PM _{2.5} тоосонцрын хэмжилт	2-15
График 2-5. PM ₁₀ тоосонцрын хэмжилт	2-16



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ОРШИЛ

Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймагт байрлах Бетон зуурмагийн үйлдвэртээ 2022 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Баялаг Эко ХХК-иар хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд улмаар 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тус 2022 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу Баялаг Эко ХХК боловсрууллаа.



БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Сонголон Хайрхан ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011179051 Регистрийн дугаар: 5276764 Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг Утас: +976 98009669 +976 99220394 Цахим шуудан: songolon_h@yahoo.com

1.2 ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг

Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлана. Төслийн талбайн хэмжээ 0.8664 га бөгөөд байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил

Сонголон Хайрхан ХХК нь Талын торгон зам ХХК-иас нэмэлт бодис хадгалах агуулахыг түрээслэн ажилладаг.

1.2.2 Үйлдвэрийн байгууламж

Тус үйлдвэр нь оффисын зориулалттай контор, 369 м² байр, үйлдвэрлэлийг шууд удирдан хянах 16 м² байр зэргээс бүрдэнэ.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 1-2. Ажилчдын байр



Зураг 1-3. Химийн бодисын агуулах

1.2.3 Үйлдвэрийн хүчин чадал

Сонголон Хайрхан ХХК нь чанарын шаардлага хангасан бетон зуурмагийн өвөл зуны нэмэлт бодисыг Талын торгон зам ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч, үйл ажиллагаандаа ашигладаг.

Бетон зуурмагийн үйлдвэр нь жилд дунджаар 45 тн химийн нэмэлт бодис хэрэглэдэг. Бетон зуурмагийн үзель нь цагт 90 м³ бетон зуурмаг зуурах хүчин чадалтай бөгөөд уг үйлдвэрт 4 хүн ажилладаг. Үйлдвэрлэлийн технологийн бүтцийг Зураг 1-4-т тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 1-4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн бүтэц

1.2.4 Бүтээгдэхүүний найрлага/орцын мэдээлэл

Бетон зуурмагийн зохистой найрлагыг цементийн анги, дүүргэгчийн шинж чанар, нэмэлтийн төрлөөс хамааруулан тухай бүр зохицуулан сонгодог бөгөөд C7.5-C40 ангийн M100-M500 маркийн хооронд бетон зуурмаг үйлдвэрлэдэг. Үүнд бетон зуурмагийн анги, маркаас хамаарч 1 м³ бетон зуурмагт ус цементийн харьцаа 0.35-0.53 байх ба 980-1100 кг элс, 740-840 кг дайрга, 160-195 л ус, 260-550 гр цемент, 2.6-5.5 гр нэмэлт бодис тус тус хэрэглэдэг.

1.2.5 Үйлдвэрийн үндсэн түүхий эд

Түүхий эд материал цементийг цементвозоор тээвэрлэн зуурмагийн үзелийн цементийн силосонд шахна. 7 хоногийн нөөцтэйгөөр үйл ажиллагаагаа явуулна. Элсийг тусгайлан зассан бетондсон талбайд буулгаж хадгална. Хайрга дайргыг тусгайлан зассан зориулалт бүхий бетондсон талбайд фракц фракцаар нь ангилан буулгаж хадгална. Ойролцоогоор 100,000 м³-ийн нөөцтэйгөөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зохицуулалт хийдэг байна.

Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох цементийг Хөтлийн “Цемент-Шохой” ТӨХК-иес тусгай зориулалтын цемент юузаар тээвэрлэж авдаг. Цемент хадгалах 150 тонны багтаамжтай 2 ш, 120 тонны багтаамжтай 1ш силостой мөн 3000-4500 м³ элс болон дайрга агуулах талбайтай. Дүүргэгч материал болох 0-5 мм элс, 10-20 мм дайргыг өөрийн компанийн элсэн карьер болгон бутлан ангилж боловсруулах үйлдвэрээс авдаг.

Хүснэгт 1-1. Бетон зуурмагт хэрэглэгдэх материалууд

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нийлүүлэгч	Сарын хэрэгцээ
1.	цемент	П-42,5	Хөтөл “ЦШ” ХК	2000 тн
2.	хайрга, дайрга	5-10,10-20 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	4000 м ³
3.	элс	0-5 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	3000 м ³
4.	Нэмэлт	Уян налархайжуулагч, усны орц багасгагч	“Талын торгон зам” ХХК	14 тн

Дүүргэгч материал: Дайрганы ширхэгийн хэлбэр нь үндсэн чулуулгийн төрөл, бүтэц болон бутлах төхөөрөмжийн төрөл, ажиллах зарчмаас хамаарна. MNS 0390:1998, MNS 0392:2014 стандартуудын шаардлага хангасан дайрга байх ба энэ тохиолдолд нимгэн үзүүрлэг хэсэг нь 15%-ийн бага буюу 2-5 %-ийн хооронд байдаг. Элсний ширхэгийн модуль нь >2.5 >3.0 байдаг бол 2.68 (том ширхэглэлтэй элс) тоос шавар шорооны хольц 0.4 %-иас ихгүй байдаг.



Элс: бетон зуурмагт хэрэглэгдэх элс нь 2.5 мм-с 0.14 мм хүртэл шигшүүрээр шигшигддэг бөгөөд MNS 0392 :2014 стандартын шаардлага хангасан элс юм.

Нэмэлт бодис: Бетоны физик- механик чанар (дундаж нягт, бат бөх, удаан эдэлгээт чанар, ус-хүйтэн-хортой үйлчлэл тэсвэрлэх чанар гэх мэт) зэрэг үзүүлэлтүүдийг тохируулах, цемент хэмнэх гэх мэт олон зорилгоор бетонд янз бүрийн нэмэлтийг цементийн жингийн тохирох хувийг нэмнэ. Бетон зуурмагт хэрэглэгдэх нэмэлт бодисыг эрдэс гаралтай болон химийн гаралтай нунтаг нэмэлтүүд гэж хоёр ангилна.

- *Химийн нэмэлт:* Бетоны физик-механикийн болон технологийн шинж чанарыг шаардлагатай чиглэлд өөрчлөх үйлчилгээтэй. Усны орц багасгаж, барьцалдах хугацааг удаашруулах нэмэлтүүд лигносульфатын натри, кальци, аммонын давсууд хамаарна.
- *Эрдэс гаралтай нунтаг элементүүд:* эдгээр нэмэлтүүдийн үндсэн хэсэг нь шиллэг төлөвийн цахиурын исэл байна. Энэ исэл нь ердийн нөхцөлд портландцементийн бэхжилтийн үед түүнийг бүрдүүлэгч эрдсүүдийн гидролизоор үүссэн шохойн гидраттай урвалд орж өндөр бат бэхтэй төдийгүй үзүүлэлт сайтай шинэ нэгдэл үүсгэнэ.

MZ-01, MZ-02 бүтээгдэхүүн нь химийн орц найрлагын хувьд поликарбоксилатын нийлмэл эфир давамгайлсан бөгөөд натри, кальци, давс бүхий полимерийн нэгдэл юм.

1.2.6 Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал

Поликарбоксилат төрлийн нэмэлт нь усны хэрэглээг 30% багасгаж, уян налархайжуулан, бат бэхийг нэмэгдүүлж, нягтаршил сайтай болгодог шинж чанар агуулснаараа бусад төрлийн нэмэлтүүдийг халж чадсан. Поликарбоксилат буюу ПИСИ (PC) нэмэлт бөгөөд бетонд нэмэлт хэрэглэснээр 1м³ бетонд хэрэглэгдэх усны зарцуулалтыг багасгаж, уян налархайжуулах чанарыг сайжруулж, бат бэхийн үзүүлэлтийг өндөрсгөж, бетонд агаарын агууламжийг үүсгэж бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж, арматурыг зэврэлтээс хамгаалж, ан цав хагарлаас хамгаалан, ус тусгаарлах гэх мэт олон төрлийн үйлчилгээ үзүүлж бетоны механик чадварыг дээшлүүлдэг маш олон талын ашиг тустай. Мөн хүйтний үед бетон доторх ус хөлдөн эзлэхүүнээ тэлсний улмаас бетоны гадаргууд талст болон ан цав хагарал үүсдэг. Тиймээс агаар үүсгэгчтэй нэмэлтийг хэрэглэснээр бетон дотор нүх сүвний нимгэн хана үүсгэн бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж мөн бетоной ажиллах боломжийг нэмэгдүүлж эдэлгээ, насжилтыг уртасгадаг.

1.2.7 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Үйлдвэрт дараах тоног төхөөрөмжийг ашигладаг.

Хүснэгт 1-2. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Тоног төхөөрөмж	тоо	марк	Хүчин чадал
1.	200 тн пресс	1ш	STYE-2000	220V
2.	Автомат шигшүүр	1ш	STSJ-3	220V
3.	Хатаагуур зуух	1ш		220V
4.	1000 нарийвчлалтай жин	1ш	HS420S	-
5.	30кг лабораторийн жин	1ш	JSB30-1	-
6.	Агаар агууламж үздэг багаж	1ш	-	-
7.	Цилиндр сав	3ш	-	2000мл, 500мл, 100мл
8.	Лабораторийн 50л багтаамжтай зуурдаг тогоо	1ш		220V
9.	100×100×100 хэв	30ш		
10.	52м-ын помп	1 ш		
11.	Миксер машин	7 ш		
12.	Бетон зуурах тогоо	1 ш		



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Тоног төхөөрөмж	тоо	марк	Хүчин чадал
13.	Туузан дамжуулагч	1 ш		

1.3 ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж: Тус үйлдвэр нь Дархан хотын төвийн шугамаар цахилгааны хэрэглээгээ хангадаг.

Усан хангамж: Тус компани нь Дархан-Ус суваг ХК-тай цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээтэй.



БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулсан.

Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 6,899,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. БОМТ-ийн зардлын хураангуйг Хүснэгт 2-1-д тусгав.

Хүснэгт 2-1. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,500,000.0
2.	Байгаль орчныг Ногоон байгууламжийн төлөвлөгөө	314,000.0
3.	хамгаалах Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,400,000.0
4.	төлөвлөгөө Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	985,000.0
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000.00
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,700,000.00
Нийт зардал		6,899,000.00



2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Тоног төхөөрөмж тээвэрлэх машин механизмын нөлөөгөөр талбайн ойр орчимд тоосжилт үүсэх

Эдгээр агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар 2022 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-2-д тусгав. Үүнд:

- Үйлдвэрийн талбай дахь замын сүлжээг сайжруулж, шороон замыг дагтаршуулах
- Үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн оношилгоо, үзлэгт хамруулж, холбогдох засварыг хийх

Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Үйлдвэрийн талбай дахь замын сүлжээг сайжруулж, шороон замыг дагтаршуулах, нягтаршуулах	Үйлдвэрийн хашаан дах нийт 0.8 га талбайд сар бүр тогтмол нягтаршуулалт хийж, тоосжилт дарах усалгааг 5-9 сард 10 удаа хийж тоос, шороог дарж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулж ажилласан бөгөөд нэг удаагийн усалгаанд 20 тн ус ашигладаг. Усыг үйлдвэрийн уснаас авах бөгөөд 2022 онд усны төлбөрт 1,897,000 төгрөг төлсөн.	100 %
2.	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг оношилгоо, үзлэгт хамруулж, холбогдох засварыг хийх	Үйлдвэрт нийт 4 ш бетон зуурмагийн миксер ашигладаг бөгөөд бүх техник хэрэгслүүдийн үзэг оношилгоог аймгийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд 2022 онд хамруулж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	100 %

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зураг, баримтыг дараах зургуудад тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-1. Үйлдвэрийн хашаан доторх шороон замыг дагтаршуулсан байдал



Зураг 2-2. Үйлдвэрийн зам талбайг усалж буй байдал



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical Certificate

Урсгал дугаар: 8269JAA
Модель: North Benz ND525
Анхилал, модолгуурийн багтаамж: 9726, C, P кг
Бүх жин: 25000 кг, Ө жин: 11470 кг
Даав, суудлын тоо: 13530 кг, 3
Төрөл: Миксер
Зориулалт: Тусгай
Аргын дугаар: LBZF46EB37A04793

ТЕХНИКИЙН ХЯАЛТЫН ҮЗЛЭГ
TECHNICAL INSPECTION

Ош, Сар, Өдөр: 2022.06.04
Техникийн байдал: Техникийн байдал: Техникийн байдал
Тусгай үзэг: Тусгай үзэг: Тусгай үзэг

2022.06.04
2022.06.04
2022.06.04

Зураг 2-3. North Benz маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical Certificate

Урсгал дугаар: 0741143
Модель: ZOOMLION
Анхилал, модолгуурийн багтаамж: 25000 кг, Ө жин: 13770 кг
Бүх жин: 25000 кг, Ө жин: 13770 кг
Даав, суудлын тоо: 13770 кг, 3
Төрөл: Миксер
Зориулалт: Тусгай
Аргын дугаар: 1614B227553
Бүхжээний дугаар: 170512H45K07780

ТЕХНИКИЙН ХЯАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ
MGL
Хувийн үзэг: 2018-02-15
2017-01-15
17.04.2019
2019.03.07
2020.03.19
2021.03.09

Өөрчлөлт: 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100

Тусгай тэмдэглэл: Тусгай тэмдэглэл

№ 01217777

Зураг 2-4. Zoomlion маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical Certificate

Урсгал дугаар: 7700YHY
Модель: HYUNDAI HD270
Анхилал, модолгуурийн багтаамж: 27900 кг, Ө жин: 12900 кг
Бүх жин: 27900 кг, Ө жин: 12900 кг
Даав, суудлын тоо: D6CA4095319
Төрөл: Миксер
Зориулалт: Тусгай
Аргын дугаар: KMCDH18S94C036247

ТЕХНИКИЙН ХЯАЛТЫН ҮЗЛЭГ
TECHNICAL INSPECTION

Ош, Сар, Өдөр: 2020.10.22
Техникийн байдал: Техникийн байдал: Техникийн байдал
Тусгай үзэг: Тусгай үзэг: Тусгай үзэг

2020.10.22
2021.05.22
2022.07.21

Зураг 2-5. Hyundai маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical Certificate

Урсгал дугаар: 6533JAP
Модель: HYUNDAI HD270
Анхилал, модолгуурийн багтаамж: 27900 кг, Ө жин: 12900 кг
Бүх жин: 27900 кг, Ө жин: 12900 кг
Даав, суудлын тоо: C.100 - 3
Төрөл: Миксер
Зориулалт: Тусгай
Аргын дугаар: L10R5W9K36800022

ТЕХНИКИЙН ХЯАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ
MGL
Хувийн үзэг: 2018.04.14
2019.04.14
2020.04.14
2021.04.14
2022.04.14

Өөрчлөлт: 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100

Тусгай тэмдэглэл: Тусгай тэмдэглэл

№ 02293083

Зураг 2-6. Hyundai маркийн миксер, үзлэг оношилгоонд хамрагдсан хуудас



2.2.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын гадаргад дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Хүнд машин механизмын дотоод шаталтын хөдөлгүүрээс хорт хий ялгарч хөрс бохирдуулах
- Үйлдвэрийн сул талбайг зүлэгжүүлээгүй, хатуу хучилттай болгоогүй тохиолдолд хөрс талхлагдах
- Нэгдсэн хогийн цэгт хог хаягдлын цуглуулаагүй улмаас хог хаягдал салхиар зөөвөрлөгдөх
- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах, улмаар саармагжуулаагүйн улмаас хөрсөнд нэвчин хөрсийг бохирдуулах

Эдгээр хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар 2022 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-3-д тусгав. Үүнд:

- Үйлдвэрээс ажилчдын байр хооронд явган хүний зам болон авто замыг байгалийн чулуугаар байгуулах
- Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс зэрэг саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах

Хүснэгт 2-3. Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Үйлдвэрээс ажилчдын байр хооронд явган хүний зам болон авто замыг байгалийн чулуугаар байгуулах	Үйлдвэр ажилчдын байр хоорондын авто болон явган хүний замыг сайжруулж, хатуу хучилттай болгосон.	100%
2.	Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс зэрэг саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах	Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд саармагжуулах, гал унтраах хэрэгслийг үйлдвэрийн хашаанд болон харуулын байшингийн хажууд тус тус байршуулсан.	100%

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зураг, баримтыг дараах зургуудад үзүүлэв.



Зураг 2-7. Үйлдвэр ажилчдын байр хоорондын хатуу хучилттай болгосон зам



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-8. Гал унтраах болон саармагжуулах хэрэгсэл

Мөн үйлдвэрийн барилга, байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглах галын аюулгүй байдлын 0002567 тоот дүгнэлтийг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр аймгийн онцгой байдлын газраар хийлгэж, гаргуулсан. (Галын аюулгүй байдлын дүгнэлтийг хавсралтаар оруулав).

2.2.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар үйл ажиллагаанд ашиглагдах усыг Дархан-Ус суваг ХК-аас хангах бөгөөд усан орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл харьцангуй бага гэж үнэлсэн байна. Харин 2022 оны БОМТ-нд усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд ил задгай хог хаяснаар усан орчин бохирдохоос сэргийлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, тогтмол хугацаанд холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж, сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргүүлж байх ажлыг төлөвлөсөн байна.

2022 оны усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-4-д тусгав.

Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Хог хаягдлын менежментийг сайжруулах	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ахуйн, дахин ашиглагдах, аюултай хаягдал гэж ангилан ялгадаг бөгөөд дахин ашиглагдахгүй энгийн хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай 2022.09.01-ний өдөр байгуулсан № 26 тоот гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг.	100%

Үүнээс гадна Сонголон хайрхан ХХК нь Дархан-Ус суваг ХК-тай цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх аж ахуй нэгжийн гэрээг 2017 онд байгуулан улмаар жил бүр усны хэрэглээг тооцож, дүгнүүлэн, төлбөр тооцоог төлж ажиллаж байна. Тус гэрээний дагуу 2022 оны байдлаар үйлдвэрт нийт 460 м³ ус ашиглан, 22,560 төгрөгийн суурь хураамжаар нийт 1,897,000 төгрөгийг төлсөн байна. (Хог тээврийн гэрээ болон төлбөр төлсөн актыг хавсаргав).

2.2.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт дараах гол болон болзошгүй нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- Тээвэрлэх явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр зам дагуух ургамлан нөмрөг талхлагдах
- Төслийн талбайд хүн машины хөдөлгөөнөөр үйлдвэрийн талбай болон ажилчдын тосгоны талбайн ойр орчмын ургамлан нөмрөг талхлагдах, доройтох
- Химийн бодисын буруу хадгалалт тээвэрлэлт зэргээс үүдэн сав баглаа боодол задарч химийн бодис гадагш алдагдах, асгарч гоожих улмаар ургамлан нөмрөг бохирдож болзошгүй

2022 оны БОМТ-нд усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд үйлдвэрийн талбайн 10 хувиас багагүй талбайд мод тарих ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлтийн тайланг “Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт”-ийн хэсэгт тусгав.

Мөн БОМТ-нд тусгасан ногоон байгууламжийн тохижилтын ажлаас гадна үйлдвэрээс оффис хүртэл 0.01 км замыг хатуу хучилттай болгосон, үйлдвэрийн миксер явах зам талбайг нягтаршуулан, тоос дарах усалгааг 5-9 сард долоо хоног бүр тогтмол хийж, химийн бодисын тээвэрлэлт, ашиглалтын үйл ажиллагааг тогтмол хянаж, орчны ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг хянаж, бууруулж төлөвлөгөөг 100% биелүүлэн ажилласан.

2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд ногоон байгууламжийн төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн талбайн 10 хувиас багагүй талбай буюу 0.08664 га талбайд ногоон байгууламж байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Сонголон Хайрхан ХХК нь үйлдвэрийн хашаан доторх хатуу хучилтгүй талбайг зүлэгжүүлэх, мод тарих ажлын хүрээнд үйлдвэрийн хашаанд 2 ш гацуур, 7 ш агч, 1 ш улиас буюу нийт 10 ш модыг тарьж, ургуулан арчилгаа тордолгоог 100%-ийн биелэлттэй хэрэгжүүлж байна.

2022 оны орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийг Хүснэгт 2-5-д тусгав.

Хүснэгт 2-5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Үйлдвэрийн талбайн 10 хувиас багагүй талбай буюу 0.08664 га талбайд ногоон байгууламж байгуулах	Энэхүү ажлын хүрээнд үйлдвэрийн хашаанд 2 ш гацуур, 7 ш агч, 1 ш улиас буюу нийт 10 ш модыг тарьж, ургуулан арчилгаа тордолгоог 100%-ийн биелэлттэй хэрэгжүүлж байна.	100%

Энэхүү ажлын биелэлтийг доорх зурагт тусгав.



Зураг 2-9. Үйлдвэрийн хашаанд тарьсан Агч мод



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-10. Ажилчдын байрын урд тарьсан гацуур, улиас

2.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах, гэнэтийн ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 1,400,000 төгрөг зарцуулахаар дараах ажлуудыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байгаа эсэхийг шалгах
- ХАБЭА сургалт зохион байгуулах
- Асгаралтад анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах, ажилчдад энэ талаар сургалт зохион байгуулах

2022 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-6-д тусгав.

Хүснэгт 2-6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байгаа эсэхийг шалгах	Үйлдвэрт 2012 онд Эс Эй Эн Ди ХХК-иар 6/0.4 кВ-ын ЦДАШ иж бүрнээр, 350 метрийн 6 кВ-ын кабель, 630 кВА хүчний трансформатор 1 ш, ачаалал таслагч 400 А газардуулагч 1 ш, ПКТ/50 гал хамгаалагч 3 ш, РВО 6 кВ хүчдэл хязгаарлагч 3 ш, 0.4 кВ-ын шитний хайрцаг 2 ш, 1000/5 гүйдлийн трансформатор 1 ш, ААБЛ 3 х 70 20 метрийн кабель, DSS-122 тоолуур 1 ш тус тус суурилуулсан. (Зураг 2-11) (Газардуулах байгууламжийн паспорт, цахилгааны байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын акт зэргийг хавсралтаар оруулав)	100%
2.	ХАБЭА сургалт зохион байгуулах	Бетон зуурмагийн үйлдвэр нь нийт 20 ажилтантай бөгөөд ХАБЭА сургалтыг шинээр ажилтан авах бүрт, мөн жил бүр ХАБЭА давтан сургалтыг зохион байгуулдаг. Үүний дагуу 2022 онд компанийн нийт 20 ажилчдыг ХАБЭА сургалтад хамруулсан байна.	100%
3.	Асгаралтанд анхаарал хандуулж холбогдох	Сонголон Хайрхан ХХК нь 2022.04.10-ний өдрийн № 12 тоот компанийн дотоод	100%



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
	журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай. Мөн ажилчдад энэ талаар сургалт зохион байгуулах	тушаалаар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулж, асгаралтаас сэргийлэх дотоод журмыг боловсруулан, түүнийг дагаж мөрдөн ажиллаж байна.	

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын холбогдох зургийг доор тусгав.



Зураг 2-11. Үйлдвэрт суурилуулсан газардуулга



Зураг 2-12. Ажилчид сургалтад хамрагдаж буй байдал

2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд ахуйн болон аюултай хог хаягдал үүсэхээс сэргийлж, дараах ажлуудыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж гэрээт байгууллагаар тогтмол тээвэрлүүлэх



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- Хогийн сав, түүний орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх
- Ажилчдыг ил задгай хог хаягдал хаяхгүй байх болон ил задгай бие засахгүй байх санамж, зааварчилгааг тогтмол өгөх
- Хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын талбайд гүйцэтгүүлэх
- Бетоны нэмэлт бодисын сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн талбай дээр аюултай хог хаягдлын савыг бэлтгэж хаягжуулан эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэх

2022 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-7-д тусгав.

Хүснэгт 2-7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлтийн хувь
1.	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж гэрээт байгууллагаар тогтмол тээвэрлүүлэх	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ахуйн, дахин ашиглагдах, аюултай хаягдал гэж ангилан ялгадаг бөгөөд дахин ашиглагдахгүй энгийн хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай 2022.09.01-ний өдөр байгуулсан № 26 тоот гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг. Мөн Дархан сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүрт төлдөг.	100%
2.	Хогийн сав, түүний орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Хог хаягдлын цэгийн ойр орчимд сард 2 удаа цэвэрлэгээ, ариутгалыг хийдэг.	100%
3.	Ажилчдыг ил задгай хог хаягдал хаяхгүй байх болон ил задгай бие засахгүй байх санамж, зааварчилгааг тогтмол өгөх	Үйлдвэрийн эргэн тойронд нийт 7 ш санамж бичгийг нааж, ажилчдад зааварчилгааг тогтмол өгдөг.	100%
4.	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг зориулалтын талбайд гүйцэтгүүлэх	Үйлдвэрт ашиглагдах тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын хэсэгт тухай бүрт засаж хэвийн ажиллагааг хангуулан ажилладаг.	100%
5.	Бетоны нэмэлт бодисын сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн талбай дээр аюултай хог хаягдлын савыг бэлтгэж хаягжуулан эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэх	Бетоны нэмэлт бодисыг Талын Торгон Зам ХХК-тай байгуулсан 2021 оны №2021/11 тоот бараа нийлүүлэх гэрээгээр худалдан авдаг бөгөөд 1 тонны зориулалтын сав баглаа боодолтойгоор тусгай зориулалтын битүүмжлэлтэй авто машинаар тээвэрлэгдэн ирдэг. Бетоны нэмэлтийн сүлласэн хоосон савыг тухайн байгууллагад буцааж ачиж явуулдаг. 2022 оны байдлаар 49 тн нэмэлт бодис хэрэглэсэн бөгөөд 49 ш хоосон савыг Талын торгон зам ХХК-д хүлээлгэн өгсөн.	100%

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг доорх зурагт тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-13. Хог хаягдлыг ангилан цуглуулах сав, хогийн цэг



Зураг 2-14. Бетон нэмэлт бодисын сав баглаа боодол



Зураг 2-15. Хогийн цэг түүний ойр орчимд цэвэрлэгээ хийж буй байдал



Зураг 2-16. Ил задгай хог хаягдал хаях, бие засахыг хориглосон санамж



Зураг 2-17. Үйлдвэрийн засварын талбай

Хог хаягдлын гэрээ, Химийн бодис нийлүүлэх гэрээг хавсаргав.

2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2022 оны БОМТ-нд Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт агаарын чанарт орчны тоосжилтыг тодорхойлуулах, хөрсөн бүрхэвчид хөрсний ерөнхий химийн үзүүлэлтийг 3 цэгт шинжлүүлэх, ургамлан нөмрөгт мониторинг хийх зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна.

Хяналт, шинжилгээний ажлуудыг төлөвлөсөн хуваарийн дагуу Баялаг Эко ХХК хийж гүйцэтгэн, магадлан итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлсэн хариуг тайланд хавсаргав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-8-д тусгав.

Хүснэгт 2-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлтийн хувь
1.	Агаарт орчны тоосжилт (PM _{2.5} ,	<ul style="list-style-type: none"> Баялаг Эко ХХК 10-р сард DustTrak DRX aerosol monitor 8533 багажийг ашиглан агаарт агуулагдах PM_{2.5}, PM₁₀ болон нийт 	100%



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлтийн хувь
	PM10 TSP) болон агаар бохирдуулагч хий (SO ₂ , NO ₂ ,) тодорхойлуулах	тоосонцор болон дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. <ul style="list-style-type: none">Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны 09 дүгээр сард үйлдвэрийн агаарыг Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.	
2.	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлт болон хүнд металлыг 3 цэгт тодорхойлуулах	<ul style="list-style-type: none">Баялаг Эко ХХК 2022 оны 10 дугаар сард үйлдвэрийн хашаан дотор, машины зогсоол болон хяналтын нэг цэгт буюу нийт 3 цэгээс дээж авч, магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн.Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны 09 дүгээр сард үйлдвэрийн хашаан доторх хөрснөөс дээж авч Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.	100%
3.	Ургамлын мониторинг хийлгэх	Үйлдвэрийн талбайд 6-р сард 1x1 метр квадрат хэмжээтэй Раменскийн торыг ашиглан Браунбланкийн арга зүйд тулгуурлан геоботаникийн бичиглэл хийж ургамлын зүйлийн бүрдэл, тусгагийн бүрхцийг бичиглэл хийж тодорхойлсон бөгөөд ховор болон нэн ховор ургамал бүртгэгдээгүй.	100%

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг доорх зургуудад тусгав.

Агаарын чанар.

1. Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор үйлдвэрийн агаарыг шинжлүүлэхэд агаарт агуулагдах хүхэрлэг хий, азотын давхар исэл болон нийт тоосны агууламж нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байв (Зураг 2-18).



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-18. Агаарын дээжлэлт, 09-р сар

Үйлдвэрийн агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг доорх графикт тусгав.



График 2-1. Үйлдвэрийн талбайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




График 2-2. Үйлдвэрийн талбайд хийгдсэн азотын давхар ислийн агууламж




График 2-3. Үйлдвэрийн талбайд хийгдсэн нийт тоосны агууламж

Үйлдвэрийн агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байна.

2. 2022 оны 10-р сард үйлдвэрийн талбайд агаарын хэмжилтийг DustTrack 850 загварын багажаар агаарт агуулагдах $PM_{2.5}$, PM_{10} тоосонцрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-19. Агаарын хэмжилт, 10-р сар

Үйлдвэрт хэмжилт хийх үед агаарын температур 12°C, чийгшил 15 %, салхины хурд 7-10 м/с байсан. Агаарын хэмжилтийн дүнг Хүснэгт 2-9-д тусгав.

Хүснэгт 2-9. Агаарын хэмжилтийн дүн

Үзүүлэлт	PM _{2.5} (мкг/м ³)	PM ₁₀ (мкг/м ³)	Дуу чимээ (Дба)
Цэг-1	25	31.5	30
Цэг-1	28	35	34
MNS 4585:2016	50	100	60

Хэмжилтийн дүнг доорх графикт тусгав.




График 2-4. PM_{2.5} тоосонцрын хэмжилт




График 2-5. PM₁₀ тоосонцрын хэмжилт

Хэмжилтийн үр дүнгээр үйлдвэрийн PM_{2.5} болон PM₁₀ тоосонцрын 2 цэгт авсан дүн MNS.4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байв.

Хөрсөн бүрхэвч.

1. Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны 09 дүгээр сард үйлдвэрийн хашаан доторх хөрснөөс дээж авч Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн байна. Үйлдвэрийн орчны хөрснөөс ялмаг, нитрат, сульфат, аммони, урвалын орчин, цахилгаан дамжуулах чадвар зэргийг шинжлэхэд тухайн хөрс нь MNS: 3297:2019. Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэг стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байсан.
2. 2022 оны БОМТ-нд Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу хөрсний дээжийг 3 цэгт хөрсний ерөнхий химийн үзүүлэлтийг шинжлүүлэх зэрэг ажлын дагуу Баялаг Эко ХХК 2022 оны 10 дугаар сард үйлдвэрийн хашаан дотор, машины зогсоол болон хяналтын нэг цэгт буюу нийт 3 цэгээс дээж авч, хөрсний ерөнхий химийн үзүүлэлтийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний лаборатори, хүнд металлыг Инженер Геодези ХХК-ийн лабораториор тус тус шинжлүүлсэн.

Хүснэгт 2-10. Дээж авсан байршил

№	Дээжийн дугаар	Авсан байршил
1.	Дээж – 1	Үйлдвэрийн хашаан дотор
2.	Дээж – 2	Машины зогсоол
3.	Дээж - 3	Хяналтын цэг

Хөрсний дээжлэлтийг доорх зургуудад тусгав.



Зураг 2-20. Хөрсний дээжлэлт, үйлдвэрийн хашаан дотор



Зураг 2-21. Хөрсний дээжлэлт, машины зогсоол



Зураг 2-22. Хөрсний дээжлэлт, хяналтын цэг


- Үйлдвэрийн хашаан дотроос авсан дээж нь шүлтлэг урвалын орчинтой, дунд зэрэг карбонатлаг, ялзмагийн агууламж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр хөрс байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


- Машины зогсоол овоолго орчмоос авсан дээж нь хүчтэй карбонатлаг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр хөрс байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж байна.
- Хяналтын цэг орчмоос авсан дээж нь шүлтлэг урвалын орчинтой, дунд зэрэг карбонатлаг, ялзмагийн агууламж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр хөрс байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсөнд агуулагдах хүнд металлыг Никель, Кадми, Хар тугалга, Зэс, Цайр, Хром зэрэг 6 элементээр шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний дүн MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартын хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна (Зураг 2-23).





Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-23. Хөрсөнд агуулагдах хүнд металлын шинжилгээний дүн

Жич: Хөрсөнд Кадми агуулагдаагүй болно.

Ургамлан нөмрөг.

1. Үйлдвэрийн талбайд 6-р сард ургамлын мониторинг хийсэн.



Зураг 2-24. Ургамлын мониторинг хийх явц

Талбайд 1x1 метр квадрат хэмжээтэй Раменскийн торыг ашиглан Браунбланкийн арга зүйд тулгуурлан геоботаникийн бичиглэл хийж ургамлын зүйлийн бүрдэл, тусгагийн бүрхцийг тодорхойлсон бөгөөд 1x1 квадрат метр талбайд:

- ургамлан бүрхэц 90 орчим хувь,
- чулууны бүрхэц 3 хувь,
- хагдны бүрхэц 2 хувь,
- халцгай газрын бүрхэц 5 хувь байсан.

Бетон зуурмагийн үйлдвэр орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалтыг Хүснэгт 2-11-д тусгав.

Хүснэгт 2-11. Бетонон зуурмагийн үйлдвэрийн талбай орчимд бүртгээгдсэн ургамлын жагсаалт

№	Ургамлын монгол нэрс	Ургамлын латин нэр	Найлзуурын өндөр, см	Фенологийн үе шат
Asteraceae				
1.	Адамсийн шарилж	<i>Artemisia Adamsii</i> Bess.	6.5	Ургалтын үе
2.	Ямаан шарилж	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.	9.2	Ургалтын үе
3.	Маралхай шарилж	<i>Artemisia tanacetifolia</i> L.	7.9	Ургалтын үе
4.	Эмийн багваахай	<i>Taraxacum officinale</i> Wigg.	8.1	Цэцэглэлтийн үе
Brassicaceae				
5.	Бүхэл навчит багдай	<i>Dontostemon integrifolius</i> (L.) C.A.Mey.	8.7	Цэцэглэлтийн үе



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Ургамлын монгол нэр	Ургамлын латин нэр	Найлзуурын өндөр, см	Фенологийн үе шат
6.	Бууралдуу янгиц	<i>Ptilotrichum canescens C.A.Mey.</i>	7.4	Ургалтын үе
Cyperaceae				
7.	Ширэг улалж	<i>Carex duriuscula C.A.Mey</i>	4.3	Ургалтын үе
Plantaginaceae				
8.	Их таван салаа	<i>Plantago major L.</i>	6.7	Ургалтын үе
Poaceae				
9.	Саман ерхөг	<i>Agropyron cristatum (L.) P. B</i>	11.8	Ургалтын үе
10.	Нарийн цагаан суль	<i>Elymus angustus Trin</i>	7.6	Ургалтын үе
Rosaceae				
11.	Ишгүй гичгэнэ	<i>Potentilla acaulis L.</i>	3.2	Ургалтын үе

Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд дэрс-харгана-шарилжит бүлгэмдэл зонхилсон. Талбайд нийт 6 овгийн 9 төрлийн 11 зүйл дээд ургамал бүртгэгдсэн. Талбайд ховор болон нэн ховор ургамал бүртгэгдээгүй.

2.7 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны БОМТ-нд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажилчдад жилд 1 удаа сургалт зохион байгуулах, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах зэрэг ажлыг төлөвлөсөн байна.

2022 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-12-д тусгав.

Хүснэгт 2-12. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлтийн хувь
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр бодлого, журам боловсруулж мөрдөх	Сонголон Хайрхан ХХК нь жил бүр БОМТ-г боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэн БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулж дагаж мөрддөг.	100%
2.	Жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Ажилчдад жил бүр 1 удаа ХАБЭА, үйлдвэрийн осол, химийн бодистой харьцах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулдаг.	100%
3.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ байгуулсны дагуу ажилчдыг үзлэгт хамруулдаг бөгөөд хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангадаг.	100%
4.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн ЗДТГ-т хүргүүлэн өгч байх	Сонголон Хайрхан ХХК нь жил бүр БОМТ-г боловсруулан батлуулж, түүний дагуу БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулж, Дархан-Уул аймгийн БОАЖГ-т хүргүүлдэг.	100%



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг доор тусгав.

The image displays 12 individual monitoring reports for employees at the Songolon Khairkhan LLC concrete plant. Each report follows a similar structure:

- Header:** "ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮРЭДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН ХУУДАС" (Copy of the employee's monitoring report).
- Employee Information:** Name, photo, and contact details.
- Section A: General Information**
 - Company: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК
 - Address: Дархан Уул аймгийн Найрвандуу сумуудын 2-р тус.
 - Production: БЭТОН
 - Equipment: АНХИМЫН СӨГ, ТЭРӨМ ОН САР, АШИЛГАХ АЖ, ХӨСӨЙН НЭР
 - Responsible: АНХИМЫН СӨГ, ТЭРӨМ ОН САР, АШИЛГАХ АЖ, ХӨСӨЙН НЭР
 - Responsible: АНХИМЫН СӨГ, ТЭРӨМ ОН САР, АШИЛГАХ АЖ, ХӨСӨЙН НЭР
- Section B: Monitoring Data Table**

№	Үзлэгийн төрөл	Өнцөг	Өнцөг	Үзлэг хийсэн өдөр	Үзлэг хийсэн цагийн үеэр
1	Эрхт судас	1/10	1/10	1/10	1/10
2	Дотор	1/10	1/10	1/10	1/10
3	Мадрал	1/10	1/10	1/10	1/10
4	Хардлага	1/10	1/10	1/10	1/10
5	Чих хөвөр хоолой	1/10	1/10	1/10	1/10
6	Нүд	1/10	1/10	1/10	1/10
7	Шүд	1/10	1/10	1/10	1/10
8	Мас засал	1/10	1/10	1/10	1/10
9	Сурьца	1/10	1/10	1/10	1/10
10	БЭДХӨ	1/10	1/10	1/10	1/10
11	Арьс харшил	1/10	1/10	1/10	1/10
12					
13					
14					
15					
- Section C: Summary**
 - Эрүүл мэндийн нэгдсэн дүнлэлт: доогуур зурвас ТЭНЦЭНЭ, ТЭНЦЭХҮЙ.
 - Эрүүл мэндийн үзлэг хийсэн эмнэлгийн байгууллагын даргын гарын үсэг: [Signature]
 - Эмнэлгийн байгууллагын Тамга: [Stamp]

Зураг 2-25. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хуудас

Нийт 9 ажилтныг эрүүл мэндийг үзлэгт хамруулсан байна.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-26. Ажилчид сургалтад хамрагдсан нь

Сонголон Хайрхан ХХК нь улирал бүр Бетон зуурмагийн үйлдвэрийн ажилчид болон уурхайн ажилчдыг нэгтгэн оффис дээрээ сургалтыг зохион байгуулаг.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ДҮГНЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд тусгагдсан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Бетон зуурмагийн үйлдвэрийн талбай дахь замын сүлжээг сайжруулж, шороон замыг дагтаршуулсан
- Үйлдвэрийн зам талбайг усны машинаар усалдаг
- Үйл ажиллагаанд хэрэглэж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн оношилгоо, үзлэгт хамруулдаг
- Үйлдвэр ажилчдын байр хоорондын авто болон явган хүний замыг сайжруулсан хатуу хучилттай болгосон
- Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд саармагжуулах хэрэгслийг байрлуулсан
- Үйлдвэрийн хашаандаа мод тарьсан
- Ажилчдад сургалт зохион байгуулдаг
- Хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг бөгөөд хог хаягдлын бүртгэл хөтөлдөг.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан бүх ажлыг хэрэгжүүлсэн
- Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран компанийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ байгуулсны дагуу ажилчдыг үзлэгт хамруулдаг байна.

<i>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг</i>	<i>Хийх ажлын тоо</i>	<i>Хийсэн ажлын тоо</i>	<i>Биелэлт (%)</i>
<i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт</i>	6	6	100
<i>Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт</i>	1	1	100
<i>Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт</i>	1	1	100
<i>Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	3	3	100
<i>Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	7	7	100
<i>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт</i>	3	3	100
<i>Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт</i>	4	4	100
<i>Нийт</i>	25	25	100

Сонголон Хайрхан ХХК нь Бетон зуурмагийн үйлдвэртээ 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 25 ажлыг хийж гүйцэтгэн, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай ажилласан байна.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр	Хуудас
1.	Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	2
2.	Тээврийн гэрээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар	10
3.	Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан Цэвэр усаар хангах, бохир усыг татуулах гэрээ	2
4.	Усны төлбөр төлсөн баримт	8
5.	Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-тай байгуулсан Хог хаягдал тээвэрлэх гэрээ	3
6.	Хог хаягдлын бүртгэл	2
7.	Галын аюулгүй байдлын дүгнэлт	2
8.	Талын торгон зам ХХК-тай байгуулсан химийн бодис нийлүүлэх гэрээ	5
9.	Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс байгуулж, асгаралтаас сэргийлэх дотоод журам	13
10.	Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын дүгнэлт	1
11.	ШУА-ийн Палентологийн хүрээлэнгээр Палентологи судалгааны ажлын дүгнэлт	1
12.	Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн агаарын шинжилгээний хариу	1
13.	Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн хөрсний шинжилгээний хариу	1
14.	Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний ерөнхий шинжилгээний хариу	2
15.	Инженер Геодези ХХК лабораторийн хөрсний хүнд металлын шинжилгээний хариу	1